



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 11527

Есөнбулаг

┌ **Ажлын хэсэг байгуулах тухай** ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, аймгийн Онцгой комиссын 2023 оны 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу Төв суурин газрын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Дэлгэр сумын нэгдсэн халаалтын системийн үйл ажиллагаатай танилцан гарсан доголдлыг арилган тодорхой санал боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

	Ажлын хэсгийн ахлагч: Х.Баатарзориг	(аймгийн Онцгой комиссын гишүүн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Гишүүд	Д.Отгонжаргал	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Х.Лхагважав	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	Б.Лхагва-Очир	(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын улсын байцаагч)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
	Д.Чинзориг	(Дэлгэр сумын Засаг дарга)
	Б.Мөнхтөр	(Дэлгэр сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч)
Нарийн бичгийн дарга: Ц.Амарсанаа		(Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч, хошууч)

2. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, халаалт дулааны үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж цаашид авах арга хэмжээний талаарх санал танилцуулахыг ажлын хэсэг (Х.Баатарзориг)-т даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ

